

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлэх, шатлалыг өөрчлөх, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, холбогдох зардлуудыг хасагдах зардалд тооцох, тайлан гаргах хугацааг уян хатан болгох, хүний нөөцийг чадавхжуулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, бизнес эрхлэхэд татварын орчныг илүү хялбар, энгийн, ойлгомжтой болгох зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Иймд урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, мөн уулзалт, хэлэлцүүлгийн үеэр аж ахуйн

нэгжүүдээс ирүүлсэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд татварын бодлогоор дэмжих, татварын илүү таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх болон бусад санал, шаардлагуудыг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага үүсээд байна.

Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах босго, шатлалыг өөрчилнө;
- Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын хөнгөлөлтийн босго дүнг нэмэгдүүлнэ;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан тушаах, төсөвт төлөх хугацааг хойшлуулна.
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлж, GPU сервер, супер компьютер элэгдэх хугацааг 3 жил болгоно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжрах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурах, улмаар эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдал бэхжих зэрэг эерэг үр дагавартай юм.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь жижиг, дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх үндсэн зорилготой байсан.

Гэвч хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх, зээлийн хүү нэмэгдэх зэрэг нийтлэг санхүүгийн хүндрэл, эрсдэлүүд дэлхийн нийгэм, эдийн засгийн төлөвт бий болсон.

Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд татварын бодлогоор жижиг, дунд бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Канад Улс, Япон Улс зэрэг улс орнууд бизнес эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний татварын ачааллыг бууруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Мөн Бүгд Найрамдах Сингапур Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс зэрэг улсууд хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг сайжруулах, татварын орчныг энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн байна. Эдгээр татварын бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн

санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлэх, шатлалыг өөрчлөх, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварын орчныг илүү хялбар, энгийн, ойлгомжтой болгох зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн.

Иймд урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, мөн уулзалт, хэлэлцүүлгийн үеэр аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд татварын бодлогоор дэмжих, татварын илүү таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх болон бусад санал, шаардлагуудыг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулж, татварын орчныг илүү энгийн, хялбар, уян хатан болгох дараах холбогдох зохицуулалтуудыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлд тус тус тусгалаа. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах орлогын босгын хэмжээг нэмэгдүүлж, шатлалыг өөрчлөх;
- Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын хөнгөлөлтийн хамрах хүрээг нэмэгдүүлж, 2.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг 90 хүртэлх хувиар хөнгөлөх;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлж, GPU сервер, супер компьютер элэгдэх хугацааг 3 жил болгоно.
- Татварын тайлан тушаах, төсөвт төлөх хугацааг хойшлуулах зэрэг зохицуулалтуудыг тус тус тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдал бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.